МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 02 өдөр Дугаар А/144 Мөрөн сум

Гэрээ байгуулах эрх олгож,
захиалагчийн төлөөлөгч томилж,
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дүгээр зүйлийн 30.1, 48 дугаар зүйлийн 48.2.6, 46.2.7, 48.2.9, Засгийн газрын 2023 оны "Журам батлах тухай" 278 дугаар тогтоол, Сангийн сайдын 2023 оны "Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг батлах тухай" А/258 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны "Байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүрэг батлах тухай" А/95 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжихээр батлагдсан Хөгжимт драмын театрын бүжгийн гутал гүйцэтгэгч сонгох ХӨАХААГ/20240602010 дугаартай тендерт 3,000,000 (Гурван сая) төгрөгийн үнийн санал ирүүлсэн "Д.Бямбасүрэн"-тэй тендерийг зөвшөөрч, тус иргэнтэй гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсүгэй.

2. "Д.Бямбасүрэн"-тай гэрээтэй холбоотой асуудлаар захиалагчийг төлөөлж харилцах, холбогдох шийдвэрийг гаргах, нийлүүлэх барааны чанар байдал, гэрээний нөхцлүүдийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий "Захиалагчийн төлөөлөгч"-өөр аймгийн Хөгжимт драмын театрын дарга (Ж.Даваадамдин)-г томилж, бараа, үйлчилгээ хүлээн авах, нийлүүлэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Захиалагчийн төлөөлөгч:

Ж.Даваадамдин- (Аймгийн Хөгжимт драмын театрын дарга)

Ажлын хэсгийн гишүүд:

Г.Нарангэрэл- (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Соёл, спортын бодлого, үйл ажиллагааг зохион байгуулах мэргэжилтэн)

Б. Цэнддэлгэр- (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн)

Д. Бямбасүрэн- (Мөрөн сумын иргэн)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Э.Болормаа- (Аймгийн Хөгжимт драмын театрын Бүжгийн ангийн дарга)

3. Хөгжимт драмын театрын бүжгийн гутал худалдан авах гүйцэтгэгч сонгох гэрээнд заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх, гэрээний хэрэгжилтийг хангах, бараг (үйлчилгээг) хүлээн авах, гэрээг дүгнэх, санхүүжилтийн гүйцэтгэл баталгаажуулах, гэрээ болон гэрээний хэрэгжилтийн мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим

671010444

систем, хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх цогц системд тус тус нийтлэх, захиалагчийн төлөөлөгчийн чиг үүрэг хэрэгжүүлсэн тухай ажлын үр дүнг тайлагнах, тайланг хавтаст хэрэг болгон орон нутгийн архивд шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг захиалагчийн төлөөлөгч (Ж.Даваадамдин)-д, захиалагч, тендерт оролцогч (тухайн тендерт оролцсон нийт оролцогч)-ийн тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг зохион байгуулсан баримт бичиг, гэрээ дүгнэсэн акт, бараа (үйлчилгээ) хүлээн авсан шийдвэр, санхүүжилтийн гүйцэтгэл зэрэг хуульд заасан бусад баримт бичгийг цахим болон бичгийн хэлбэрээр хавтаст хэрэг болгон орон нутгийн архивд шилжүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Ж.Адьяасүрэн)-д тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсорогдог)-д үүрэг болгосугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ